



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2012 оны 09 сарын 12 өдөр

Дугаар 283

Улаанбаатар хот

“Монгол нэхмэл” ХК-ийн нэгдмэл сонирхолтой этгээдүүдээс
гаргасан саналыг зөвшөөрөх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1, 6.2.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 34.1.8, Компанийн тухай хуулийн 57.1, Санхүүгийн зохицуулах хорооны 2010 оны 163 дугаар тогтоолоор батлагдсан “Хувьцаат компанийн хувьцааг заавал болон сайн дурын үндсэн дээр худалдан авах санал гаргах ажиллагааны журам”-ыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Монгол нэхмэл” ХК-ийн нийт гаргасан 474,164 ширхэг хувьцааны 56.52 хувь буюу 267,998 ширхэг хувьцааг эзэмшигч нэгдмэл сонирхолтой этгээд болох Р.Энхтайван, С.Мандухай, Э.Энхжин нараас тус хувьцаат компанийн бусад хувьцаа эзэмшигчдийн өмчлөлд байгаа нийт хувьцааны 43.48 хувь буюу 206,166 ширхэг хувьцааг нэг бүрийг нь 3,293 /гурван мянга хоёр зуун ерэн гурав/ төгрөгөөс доошгүй үнээр худалдан авах санал гаргасныг зөвшөөрч хүчинтэй байх хугацааг 2012 оны 9 дүгээр сарын 12-ний өдрөөс эхлэн ажлын 60 хоногоор тогтоосугай.

2. “Монгол нэхмэл” ХК-ийн нэгдмэл сонирхолтой этгээдүүдээс хувьцааг худалдан авахаар гаргасан саналыг зөвшөөрсөнтэй холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг нэгдмэл сонирхолтой этгээдүүдийг төлөөлж буй этгээд /Э.Энхжин/-д үүрэг болгосугай;

1/ Холбогдох хууль, журмын дагуу хувьцааг худалдан авах саналаа нийтэд сурталчилж, хуулиар хүлээсэн үүргээ хугацаанд нь биелүүлэх, хувьцааг худалдан авах саналын хугацаа дуусмагц ажлын 5 хоногт багтаан хувьцааг худалдан авах саналын хэрэгжилтийн тайланг Хороонд ирүүлэх;

2/ Санхүүгийн зохицуулах хорооны 2007 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Үнэт цаасны зах зээлийн мэдээллийн нэгдсэн сангийн тухай журам”-д заасан мэдээллийг цаг тухайд нь тогтмол ирүүлж, хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ чанд биелүүлж ажиллах;

3/ Санхүүгийн зохицуулах хорооны 2007 оны 210 дугаар тогтоолоор батлагдсан “Монголын компанийн засаглалын кодекс”-ыг мөрдөж ажиллах.

3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд тус тус даалгасгай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН